



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-60, Факс: 32-70-16
E-mail: temujin@parliament.mn
http://www.parliament.mn

2025.06.10 № ЧУХ-03/7109
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 3 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН


Х.ТЭМҮҮЖИН

О.ЦОГТГЭРЭЛ

Л.МӨНХБААТАР

Ж.ЗОЛЖАРГАЛ

Н.НОМТОЙБАЯР




Б.БАТБААТАР

Б.БАЯРБААТАР




Б.ЖАРГАЛАН



А.УНДРАА



Б.ЭНХБАЯР



А.АРИУНЗАЯА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-60, Факс: 32-70-16
E-mail: temuujin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.10 № УИХ-03/7145
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын Чуулганы Хуралдааны Дэгийн тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.


Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 15 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН



БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

БНМАУ-ын Ардын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан бөгөөд ардчилсан, шинэ Үндсэн хуульд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" хэмээн зааснаар манай улс байнгын ажиллагаатай нэг танхим (нийтийн танхим) бүхий парламентын Бүгд найрамдах улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан явдал болсон юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно. Парламентын ардчилал нь нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь парламентаас ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцаж, Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнах харилцааг хуулиар нарийвчлан зохицуулж, хууль тогтоох дээд байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, түүний гүйцэтгэл болон хуулийн биелэлтэд хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурал Ерөнхий

сайдад асуулга тавих, гишүүд асуулт асууж, хариулт авах асуудлыг энэхүү хуулийн нэмэлт өөрчлөлтөөр оруулна.

Тодорхой хэлбэл төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаанд алдаа мадаг гаргахгүйн үүднээс парламентад худал мэдээлэл өгөхгүй байх, худал мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээдэг байх, олонхын бүлэг буюу түүнээс сонгогдсон Ерөнхий сайдаас асуудаг асуулгын цагийг Улсын Их Хуралд бий болгох, уг асуулга нь нээлттэй, тэгш мэтгэлцээний үндсэн дээр өрнөдөг байх зэрэг зарчмын өөрчлөлтийг Улсын Их Хурлын тухай хууль болон, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд оруулах шаардлагатай гэж үзлээ.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна, Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнах харилцааг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлд Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх асуудлыг журамласан байгаа Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлд заасантай нийцэхгүй байх бөгөөд гүйцэтгэх засаглалын тэргүүн нь мэдээлэл хийх сэдвээ өөрөө тааллаараа сонгож, сард нэг удаа мэдээлэл хийхдээ зарим үед өөрөө бус Засгийн газрын өөр нэг гишүүнээр мэдээлэл хийлгэж байгаа нь мөн Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 8-д заасан “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхээ чуулганы танхимд хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр Улсын Их Хурлын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж, улмаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийг Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчлөх шаардлага үүсч байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлж, мэдээлэл хийж буй Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан нийтийн албан тушаалтан, бусад этгээд үнэн бодит мэдээлэл өгөх асуудлыг үүрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх харилцаа бүрэн зохицуулагдана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийн шийдвэрлэх арга хэмжээний талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Улсын Их Хурлын батлагдсанаар нийгмийн үр дагавар нь эерэг байна. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорьдугаар зүйл, Хорин нэгдүгээр зүйлийн 1, Хорин гурав, Хорин тав, Хорин зургаа, Хорин долдугаар зүйлд заасан парламентын ардчилал, парламентат ёсыг сэрээх, Улсын Их Хурлын олонхи цөөнх тэгш мэтгэлцэх, Улсын Их Хурлын гишүүд нийт иргэд, улсын ашиг сонирхолын төлөө нээлттэй, бие даасан байдлаар асуулт асууж, үг хэлж, байр сууриа илэрхийлэх зарчим хангагдаж, Үндсэн хуулийн дэг журамд нийцсэн улс төрийн соёл төлөвшин тогтох үр дагавартай гэж үзсэн.

Түүнчлэн парламентын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын Их Хуралд худал мэдээлэл өгөхгүй байх, худал мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээдэг байх, олонхын бүлэг буюу түүнээс сонгогдсон Ерөнхий сайдтай цөөнхийн бүлэг, түүний төлөөлөл тэгш нээлттэй мэтгэлцээн өрнүүлэх, сонгогч иргэдийг хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын үйл ажиллагааны мэдээллээр цаг тухайд нь хангаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох "ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангаж, хууль дээдлэх" зарчмуудыг Улсын Их Хурлын үйл ажиллагаанд баталгаажуулах, олон нийтийн Улсын Их Хуралд итгэх итгэлийг нэмэгдүүлэх эерэг үр дагавар үүсгэнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь олонх ба цөөнхөөс бүрддэг байнгын ажиллагаатай парламентыг Монгол Улсад бий болгосон ардчилсан Үндсэн хуультай нийцнэ. Хуулийн төслийг дагалдан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл мөн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулж, хамтад нь өргөн мэдүүлнэ.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" хэмээн зааснаар манай улс байнгын ажиллагаатай нэг танхим (нийтийн танхим) бүхий парламентын Бүгд найрамдах улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно.

Парламентын ардчилал нь нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь парламентаас ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Монгол Улсын Их Хурал нь 126 гишүүнтэй, төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайд тусгайлсан суудал эзэгнэж хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна.

Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан Улсын Их Хурал дахь олонх ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг, чуулганд гишүүд сонгогч иргэдээ төлөөлөн, байр сууриа нээлттэй илэрхийлж, дарамт, доромжгүй үгээ чөлөөтэй хэлдэг байхын сацуу, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй

хэрэгжих парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Түүнчлэн төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаанд алдаа мадаг гаргахгүйн үүднээс парламентад худал мэдээлэл өгөхгүй байх, худал мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээдэг байх, олонхын бүлэг буюу түүнээс сонгогдсон Ерөнхий сайдаас асуудаг асуулгын цагийг Улсын Их Хуралд бий болгох, уг асуулга нь нээлттэй, тэгш мэтгэлцээний үндсэн дээр өрнөдөг байх зэрэг зарчмын өөрчлөлтийг Улсын Их Хурлын тухай хууль болон, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд оруулах шаардлагатай гэж үзлээ.

Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонхийн эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох "спикер"-ын суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй, сонирхолын зөрчилгүй, хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцан ажиллах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзалгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонхи цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана.

Танхимын байрлал бол зөвхөн архитектур биш ба улс төрийн соёл, шийдвэр гаргах арга барилд шууд нөлөөлдөг байна.

Монголын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим нь улс төрийн чөлөөт, өрсөлдөөнт мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй, тэр байтугай чуулганы хуралдааны танхимын зохион байгуулалтын бүдүүвч зураг, байршлыг ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураар уг зураглал, байршлыг баталж ирсэн нь хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ. Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах практик шаардлагатай гэж үзлээ.

Хуулийн төслийг дагалдан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл мөн Төрийн албаны

тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулж, хамтад нь өргөн мэдүүлнэ.

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" хэмээн зааснаар манай улс байнгын ажиллагаатай нэг танхим (нийтийн танхим) бүхий парламентын Бүгд найрамдах улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно.

Парламентын ардчилал нь нээлттэй, тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь парламентаас ерөнхий сайдыг томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ.

Монгол Улсын Их Хурал нь 126 гишүүнтэй, төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайд тусгайлсан суудал эзэгнэж хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна.

Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан Улсын Их Хурал дахь олонх ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг, чуулганд гишүүд сонгогч иргэдээ төлөөлөн, байр сууриа нээлттэй илэрхийлж, дарамт, доромжгүй үгээ чөлөөтэй хэлдэг байхын сацуу, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй

хэрэгжих парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Түүнчлэн төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаанд алдаа мадаг гаргахгүйн үүднээс парламентад худал мэдээлэл өгөхгүй байх, худал мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээдэг байх, олонхын бүлэг буюу түүнээс сонгогдсон Ерөнхий сайдаас асуудаг асуулгын цагийг Улсын Их Хуралд бий болгох, уг асуулга нь нээлттэй, тэгш мэтгэлцээний үндсэн дээр өрнөдөг байх зэрэг зарчмын өөрчлөлтийг Улсын Их Хурлын тухай хууль болон, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд оруулах шаардлагатай гэж үзлээ.

Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонхийн эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох "спикер"-ын суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй, сонирхолын зөрчилгүй, хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцан ажиллах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзалгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонхи цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана.

Танхимын байрлал бол зөвхөн архитектур биш ба улс төрийн соёл, шийдвэр гаргах арга барилд шууд нөлөөлдөг байна.

Монголын Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим нь улс төрийн чөлөөт, өрсөлдөөнт мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй, тэр байтугай чуулганы хуралдааны танхимын зохион байгуулалтын бүдүүвч зураг, байршлыг ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураар уг зураглал, байршлыг баталж ирсэн нь хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ. Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах практик шаардлагатай гэж үзлээ.

Хуулийн төслөөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, хуралдааны танхимын зохион байгуулалтын үндсэн зарчим, суудлийн хуваарийн ерөнхий төлөвлөлтийг зохицуулна. Тодруулбал чуулганы хуралдаан, танхимын зохион байгуулалт нь Улсын Их Хурлын бүрэлдэхүүн хуралдаж, ард түмнийг төлөөлөх,

хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэхэд зориулагдсан байх талаарх зохицуулалт байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлж, мэдээлэл хийж буй Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан нийтийн албан тушаалтан, бусад этгээд үнэн бодит мэдээлэл өгөх асуудлыг үүрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх харилцаа бүрэн зохицуулагдана.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Улсын Их Хурлын батлагдсанаар нийгмийн үр дагавар нь эерэг байна. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, Хорьдугаар зүйл, Хорин нэгдүгээр зүйлийн 1, Хорин гурав, Хорин тав, Хорин зургаа, Хорин долдугаар зүйлд заасан парламентын ардчилал, парламентат ёсыг сэрээх, Улсын Их Хурлын олонхи цөөнх тэгш мэтгэлцэх, Улсын Их Хурлын гишүүд нийт иргэд, улсын ашиг сонирхолын төлөө нээлттэй, бие даасан байдлаар үг хэлж, байр сууриа илэрхийлэх зарчим хангагдаж Үндсэн хуулийн дэг журамд нийцсэн улс төрийн соёл төлөвшин тогтох үр дагавартай гэж үзсэн.

Түүнчлэн парламентын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын Их Хуралд худал мэдээлэл өгөхгүй байх, худал мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээдэг байх, олонхын бүлэг буюу түүнээс сонгогдсон Ерөнхий сайдтай цөөнхийн бүлэг, түүний төлөөлөл тэгш нээлтэй мэтгэлцээн өрнүүлэх, сонгогч иргэдийг хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын үйл ажиллагааны мэдээллээр цаг тухайд нь хангаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох "ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангаж, хууль дээдлэх" зарчмуудыг Улсын Их Хурлын үйл ажиллагаанд баталгаажуулах, Улсын Их Хуралд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх эерэг үр дагавар үүсгэнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй болно.

Гадаад орны туршлагаас харахад Засгийн газрыг төлөөлж Ерөнхий сайд парламентын гишүүдээс журмын дагуу урьдчилж хүргүүлсэн асуултад Парламентын танхимд ирж хариулт өгөх ба хариултаас улбаалсан асуултын хүрээнд мэтгэлцээн өрнүүлэх харилцааг хуульчилж өгдөг байна. Тухайлбал, Англи, Австрали, Шинэ Зеланд, Франц зэрэг орнуудын хувьд сар бүр хэд хэдэн удаа Парламентын асуулгын цагт Засгийн газар мэдээлэл хийж, мэтгэлцээн өрнүүлж байна. Шинэ Зеландын хувьд 7 хоног бүр Засгийн газар Парламентын асуулгад хуралдааны танхимд хариулт өгч мэдээлэл хийхийн сацуу, асуултаас хөвөрсөн

асуултуудын хүрээнд мэтгэлцээн явагдахаар чуулганы хуралдааны дэгд тусгаж өгсөн байна.

Мөн түүнчлэн парламентад гагцхүү үнэнийг мэдүүлэх, худал мэдээлэл өгөхгүй байх асуудлыг нийтийн албан тушаалтны тангарагт тусгах, хуралдаанд оролцохын өмнө тусгай хуудаст гарын үсэг зуруулах, зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох зэргээр тусгасан байна. АНУ-д парламентын танхим, шүүх танхимд үнэнийг мэдүүлэхийг хуульчилж өгсөн байх бөгөөд хэрэв зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх асуудлыг эрүүгийн хуульд тусгайлан тусгаж өгсөн байдаг байна.

Ихэнх орнуудын хувьд парламентад худал мэдээлэл өгөх асуудлыг 1-рт, үнэн бодит мэдээллийг нуун далдлах, 2-рт, парламентад худал мэдүүлэх, 3-рт, парламентад худал мэдээлэл бичиж ирүүлэх гэсэн 3 үндсэн агуулгын хүрээнд авч үзэж байна. Түүнээс гадна нийтийн албан тушаалтан хувьд парламентын хуралдаанд оролцож өөрийн үндсэн ажил, чиг үүргийн хүрээнд хийсэн мэдээллийг авч үзэхдээ “мэдэх үүрэгтэй байсан”, “мэдэх боломжтой байсан” гэсэн хүрээнд авч үздэг нь тухайн албан тушаалтны хариуцлагыг өндөржүүлж өгдөг байна.

Хуулийн төслийг дагалдан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл мөн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулж, хамтад нь өргөн мэдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.8 дах хэсэг:

"4.8.Нэгдсэн хуралдааны танхимын зохион байгуулалт нь Улсын Их Хурал хуралдаж, хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих болон ард түмний элчийн хувьд Улсын Их Хурлын гишүүд нийт иргэн, улсын ашиг сонирхлын өмнөөс үг хэлэх, нам, эвслийн бүлэг байр сууриа илэрхийлэх, олонхи, цөөнх мэтгэлцэхэд зориулагдсан байна."

2/21 дүгээр зүйлийн 21.25-21.29 дэх хэсэг:

"21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд мэдээллийг нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах болон Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.26.Энэ хуулийн 21.25-д заасан холбогдох албан тушаалтан худал мэдээлэл өгсөн, танилцуулсан гэж үзвэл гишүүн хуралдаан даргалагчид санал гаргаснаар Тамгын газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн мэдээллийн үнэн зөв, бодит эсэх асуудлыг ажлын 5 өдрийн дотор хянаж, дүгнэлт гаргана.

21.27.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх албан тушаалтан болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон этгээд хариуцсан ажил үүргийн хувьд мэдэх ёстой, мэдэх боломжтой мэдээллээ үнэн зөв, бүрэн гүйцэт өгөх тухай сануулж, баталгаажуулах хуудаст гарын үсэг зуруулах ажлыг Тамгын газар зохион байгуулна.

21.28.Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг нуун дарагдуулсан улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлыг тухайн нам, эвслийн бүлэг, эсхүл 10-аас доошгүй гишүүн гарын үсэг зурсан бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.11-д зааснаар холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

21.29.Байнгын хороо энэ хуулийн 22.3.6-д заасны дагуу санал боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

21.30.Нэгдсэн хуралдаанд худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг нуун дарагдуулсан нийтийн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 32.7-д заасан хариуцлага хүлээлгэнэ."

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 21 дүгээр зүйлийн 21.24 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсэг:

"3.1.Улсын Их Хурлын үндсэн зорилт нь ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршино.

3.2.Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хууль тогтоох эрх мэдлийг өөрт дангаар хадгалж, төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэн, түүний үндсийг тодорхойлж, хууль тогтоох, төсөв батлах, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүрэгтэй."

2/21 дүгээр зүйлийн 21.24 дэх хэсэг:

"21.24.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх үүрэгтэй. Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо, Хяналт шалгалтын түр хорооны сонсголд оролцож байгаа этгээд үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ."

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийн дугаарыг "4.9" гэж, 21 дүгээр зүйлийн 21.25 дахь хэсгийн дугаарыг "21.31" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.25 дахь хэсгийн ", санаатайгаар худал мэдээлэл өгсөн" гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг